



САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН МАТЕРИАЛ**

MSE: 

Улаанбаатар хот

2021 он

ХУРЛЫН МАТЕРИАЛЫН АГУУЛГА

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол;

Хурлаар хэлэлцэх асуудал;

Саналын хуудасны загвар;

Хувьцаа эзэмшигчдийн хурлын олон нийтэд зарлах зарын загвар;

Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материал;

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төсөл;

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Хурал 2021 оны 4 сарын 30-ны өдрийн 14:00 цагт эхэлж, 16:00 цагт дуусна.

1	Тооллогын комисс хурлын ирц бүртгэх, ирцийг мэдээлэх	14:00
2	Хурлын дарга хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээх	14:15
3	Хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу танилцуулга хийх Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох	14:20
4	Асуулт, хариулт	15:00
5	Санал хураалт	15:30
6	Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах	15:50
7	Хурлаас гарсан шийдвэрийг танилцуулж, Хурлыг хаах	16:00

Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

2021 он 3 сар 19 өдөр

Дугаар 21/18

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал**зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ийн өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, “COVID-19” буюу шинэ коронавируст халдвар дэгдсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэрэгсэл, онлайн орчинд зайны технологийг ашиглан хуралдуулах тухай зөвлөмжийг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 3 сарын 19-ний өдрийн эчнээ санал хураалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2021 оны 4 сарын 30-ны өдрийн 14:00 цагт live.ard.mn цахим хуудсыг ашиглан онлайн хэлбэрээр зарлан хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 4 сарын 12-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2021 оны 3 сарын 24-ний өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2021 оны 4 сарын 8-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, танилцуулга зэрэг бүсэд холбоотой баримт бичгийг бэлэн болгож 2021 оны 3 сарын 29-ний өдрийн дотор үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.

6. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2021 оны 4 сарын 29-ний өдрийн 14:00 цагаар тасалбар болгосугай.

7. Онлайн хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэвтрэх нууц кодыг 2021 оны 4 сарын 13-ны өдрөөс эхлэн 4 сарын 29-ний өдрийн хооронд хувьцаа эзэмшигчдэд олгосугай.

8. Хурлын даргаар Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Ганхуягийг томилсугай.

9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг

Хурал байгуулах комиссын гишүүд:

Маркетинг, Борлуулалт эрхэлсэн захирал Ц.Бархас

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х.Хулан

Үйл ажиллагаа эрхэлсэн захирал Ж.Алтангүний

Хянан нийцүүлэлт эрхэлсэн менежер С.Анар-Эрдэнэ

Хөрөнгө оруулалт эрхэлсэн захирал Э.Амарбаясгалан

Санхүү эрхэлсэн захирал Б.Золбоо

10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:

Г.Алтансүх /Блүмсбюри Секьюритис ҮЦК ХХК/

Тооллогын комиссын гишүүд:

Б.Ариунзул /Блүмсбюри Секьюритис ҮЦК ХХК/

Д.Мөнчанар /Ап финанс ХХК/

11. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Ганхуягт даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



П.БАТБАЯР

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2021 оны 3 сарын 19-ний өдрийн
21/13 тоот тогтоолын 1-р хавсралт/

**2021 ОНЫ 4 САРЫН 30-НЫ ӨДӨР ХУРАЛДАХ
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

1. Компанийн 2020 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг танилцуулах;
2. Компанийн 2020 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах;
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох.

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2021 оны 3 сарын 19-ний өдрийн
21/13 тоот тогтоолын 2-р хавсралт 1/

**АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №1)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2021 оны 4 сарын 30-ны өдрийн 14:00 цагт
live.ard.mn веб хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.			

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч Үнэт цаасны компани (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэх нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
4. Завсарласан болон балласан, залруулгатай санал авах хуудсыг хүчингүйд тооцно.
5. Саналыг саналын хуудсаар эсвэл цахимаар өгөх боломжтой.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2021 оны ... -р сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ / _____ /

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №2)

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2021 оны 4 сарын 30-ны өдрийн 14:00 цагт live.ard.mn веб хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
Ердийн гишүүд		
1	Чулуун овогтой Ганхуяг	
2	Бруно Е. Рашле	
3	Авир овогтой Сүхдорж	
4	Одончимэд овогтой Одбаяр	
Хараат бус гишүүд		
1	Пүрэвжаргал овогтой Батбаяр	
2	Мөнх-Очир овогтой Сэргэлэн	
3	Чулуун овогтой Мөнхбат	
4	Михаил Зелдович	
5	Арнауд Вентура	

Санамж: ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй (100*9гишүүн=900) болох болно. Хувьцаа эзэмшигч нь саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй. Хувилбар А: Хувьцаа эзэмшигч нь нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно. Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч нь нийт 900 саналын эрхийн 400 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 4 хүртэл нэр дэвшигчид, 500 эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 5 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2021 оны ... -р сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ / _____ /

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

/Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2021 оны 3 сарын 19-ний өдрийн
21/13 тоот тогтоолын 3-р хавсралт/

"АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь шинэ төрлийн коронавирусын /COVID-19/ болзошгүй эрсдэлээс урьдчилсан сэргийлэх үүднээс Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэрэгслийг ашиглан хуралдуулах боллоо. Хувьцаа эзэмшигч та хурлын өдөр live.ard.mn цахим хуудсаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаа оролцоно уу.

ХУГАЦАА: 2021 оны 4 сарын 30-ны өдрийн 14:00 цагт live.ard.mn цахим хуудсаар хуралдана. Та цахим хуралд оролцохдоо өөрийн регистрийн дугаар, урьдчилж авсан нууц кодоор нэвтэрнэ үү.

КОМПАНИЙН ОНООСОН НЭР: "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК

ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн 2020 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг танилцуулах;
2. Компанийн 2020 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах;
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох.

Бүртгэлийн өдөр: 2021 оны 4 сарын 12-ны өдөр

ХУРАЛД БЭЛТГЭХ ЯВЦАД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ:

1. Компанийн 2020 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;
2. Компанийн 2020 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлт;
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;
4. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар;
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл.

Хувьцаа эзэмшигч та 2021 оны 4 сарын 30-ны өдрөөс өмнө ажлын өдрүүдэд 9:00-18:00 цагийн хооронд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байрны 2 давхарт ирж хурлын материалтай танилцах боломжтой.

Хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилан өгөх боломжоор хангаж Ард Секюритиз ҮЦК ХХК компанийн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байр хаягаар дамжуулан авах ба саналын хуудсыг авах сүүлийн хугацаа 2021 оны 4 сарын 29-ний өдрийн 14:00 цаг байна.

Холбоо барих хүний нэр: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х.Хулан
Утас: 7707 8080, 9944 1747

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

**КОМПАНИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**





"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Хураангуй санхүүгийн тайлангийн талаарх Хараат бус аудиторын дүгнэлт

Далай тээр 9 дугаар, ЮНЕСКО
гудамж, Сүхбаатар дүүрэг, 3-р
хороо, Улаанбаатар 14230,
Монгол улс
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 B, UNESCO street,
Sukhbaatar District-3, Ulaanbaatar
14230, Mongolia
T + 976 70 110744
+ 976 70 110799

"Ард санхүүгийн нэгдэл" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид "Ард санхүүгийн нэгдэл" ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйцээний тайланг (давшид хамтад нь "хураангуй санхүүгийн тайлан" гэх) 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Хураангуй санхүүгийн тайлан

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартаар шавардсан бусад тайлбар тодруулгуудыг иж бүрэн агуулаагүй тул "Ард санхүүгийн нэгдэл" ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2021 оны 3 дугаар сарын 31-ны өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлтэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд манай аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт өгсөн. Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудалд СТОУС 9 "Санхүүгийн хэрэглээр"-т өмчийн хэрэгшүүрт оруулсан хөрөнгө оруулалтын хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, Виртуал хөрөнгийн бүртгэл, СТОУС 16 "Түрээс"-гэй холбоотой ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөлт, СТОУС 10 "Нэгтгэсэн санхүүгийн тайлан"-д заагдсан хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийн статусыг хангах тухай зэрэг асуудлуудыг авч үзсэн.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгуулсан баталсан холбогдох дүрэм, журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын "Аудитын тухай" хуулийн дагуу хийсэн аудит даа үндэслэл энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	100,958	43,236
Дансны болон бусад авлага	1,685,343	4,912,768
Бусад санхүүгийн хөрөнгө	18,737	416,506
Бараа материал	2,112	6,231
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,243,564	551,327
Эргэлтийн хөрөнгийн дүн	3,050,714	5,930,068
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	466,025	642,006
Биет бус хөрөнгө	8,941,367	3,261,572
Ашиглах эрхтэй хөрөнгө	440,433	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	67,481,313	68,238,169
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	77,329,138	72,141,747
Нийт хөрөнгө	80,379,852	78,071,815
Өр төлбөр ба эздийн өмч		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны болон бусад өглөг	4,552,360	2,613,677
Богино хугацаат зээл	1,147,287	1,082,465
Богино хугацаат хаалттай бондын өр төлбөр	11,958,106	-
Богино хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	349,718	40,096
Богино хугацаат өр төлбөрийн дүн	18,007,471	3,736,238
Урт хугацаат өр төлбөр		
Хойшлогдсон татварын өр	3,405,208	3,070,863
Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	379,093	262,390
Урт хугацаат зээл	408,752	2,236,039
Урт хугацаат хаалттай бондын өр төлбөр	2,347,232	12,183,955

Урт хугацаат өр төлбөрийн дүн	6,540,285	17,753,247
Өр төлбөрийн нийт дүн	24,547,756	21,489,485
Эздийн өмч		
Өмч-хувьцаат	28,590,335	28,590,335
Халаасны хувьцаа	(1,414,706)	(1,414,706)
Дахин үнэлгээний нөөц	27,284,096	24,105,478
Эздийн өмчийн бусад хэсэг	13,799	13,799
Хуримтлагдсан ашиг	1,358,572	5,287,424
Эздийн өмчийн дүн	55,832,096	56,582,330
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	80,379,852	78,071,815

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	2020 он	2019 он
Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний орлого	688,461	346,333
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз	303,915	879,944
Ногдол ашгийн орлого	1,311,736	537,157
Хөрөнгө оруулалтын багцын хүүний орлого	29,984	302,225
Нийт хөрөнгө оруулалтын орлого	2,334,096	2,065,659
Бусад орлого	916,740	788,556
Борлуулалт, маркетингийн зардал	271,381	1,625,924
Ерөнхий ба удирдлагын зардал	3,183,791	3,293,038
Санхүүгийн зардал	2,876,353	1,476,353
Бусад зардал	785,887	896,380
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	(170,140)	(20,036)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	-	(34,430)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(4,036,716)	(4,491,946)
Орлогын татварын зардал (өгөөж)	(2,041)	84,204
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(4,034,675)	(4,576,150)
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц	385,328	9,348,676
Виртуал хөрөнгийн үнэлгээний нөөц	3,849,693	675,736
Бусад дэлгэрэнгүй орлогын дүн	4,235,021	10,024,412
Нийт дэлгэрэнгүй ашиг	200,346	5,448,262
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	(0.15)	(0.21)

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны онцлох үйл явдал

1 сарын 13	Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекс шинэчлэгдэж, Ард Санхүүгийн Нэгдэл, Ард Даатгал, Ард Кредит болон Монгол Шуудан компаниуд багтлаа.
2 сарын 12	Ард Секюритиз ҮЦК нь гадаад арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл авлаа.
2 сарын 19	Ард Санхүүгийн Нэгдэл нийт ашгаасаа 12.65 хувь буюу 1 тэрбум, Ард Даатгал 49.45 хувь буюу 850 сая, Ард Кредит 50 хувь буюу 1.18 тэрбум төгрөгийг тус тус ногдол ашгаар хуваарилахаар шийдвэрлэлээ.
4 сарын 1	Ард Лайф-д нэмэлт хөрөнгө оруулалт хийв.
4 сарын 27	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа анх удаа цахимаар амжилттай зохион байгууллаа.
4 сарын 29	
5 сарын 1	
5 сарын 5	АрдКойн Монголын хамгийн анхны олон улсын крипто бирж болох BitMonex-д бүртгэгдлээ.
5 сарын 25	Ирээдүйн Эзэд – Хувьцаатай Хүүхэд аян эхэллээ.
6 сарын 10	Ард Менежмент үнэт цаасны компанийн санаачилгаар байгуулагдсан Үндэсний Хувчлалын Сан Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрөл авлаа.
6 сарын 11	Хөрөнгө Оруулагч Үндэстэн аяны хүрээнд Европын холбооны улсууд болон 21 аймгаар тойрон мэдээлэл хүргүүлэх сургалт, танилцуулгаа эхлүүлээ.
6 сарын 19	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалт байдлаар явуулж нэмэлт өөрчлөлтийг баталлаа.
10 сарын 2	Ард Кредит Монгол Шуудантай хамтарсан ЕвроЖайро олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний нээлтээ хийлээ.
10 сарын 5	Ард Менежмент Үндэсний Хувчлалын Сан нэртэй Монголын анхны хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг нээж Монголын Хөрөнгийн Бирж дээр цан цохилоо.
12 сарын 14	Ард Кредит АСН+ (Automated Clearing House) банк хоорондын жижиг төлбөр тооцооны системд нэгдлээ.
12 сарын 16	Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр арилжаалагддаг Степ Голд нь Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаагаа давхар бүртгүүлэхээр болж, андеррайтераар Ард Секюритиз ҮЦК-г сонгон ажиллуулахаар боллоо.
12 сарын 26	Крипто Үндэстэн Сан нь үйл ажиллагаа эхлүүлээд 3 жилийн дараа 110 хувийн өгөөжтэй хаагдлаа.

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ГАРГАСАН ДҮГНЭЛТ

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн хурлаар хэлэлцэн компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ нь тайлант онд компанийн 2020 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдөж, Компанийн гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн шийдвэр, зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа.

Иймд 2020 он Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьд асар том амжилт, өгөөжтэй жил байсан бөгөөд гүйцэтгэх удирдлагын баг өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дайчлан ашиглан төлөвлөсөн зорилтоо биелүүлэн ажилласан гэж Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс дүгнэж байна.

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

2020 оны аудитлагдсан тайлангийн
дүнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны зөвлөмж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Грант Торнтон Аудит ХХК-аас компанийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн авч, санхүүгийн тайланг баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-д даалгасугай.

ДАРГА



П.БАТБАЯР

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ
ТОМИЛОХ**



/Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигч/

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ АНКЕТ

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр: **Чулуун**

Өөрийн нэр: **Ганхуяг**

Боловсрол: **Дээд**

Мэргэжил: **Эдийн засагч, Банк санхүүгийн менежмент**

Одоо эрхэлж байгаа албан тушаал:

Ард Санхүүгийн Нэгдэл ХК - Гүйцэтгэх захирал



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Он		Эзэмшсэн мэргэжил	Зэрэг цол
		Элссэн	Төгссөн		
Унгар, Будапешт	Budapest University of Economic Sciences	1993	1997	Эдийн засагч	Бакалавр
АНУ	Stonier/ABA	2002	2002	Мэргэжил дээшлүүлэх сургалт	
АНУ	Shore bank	2002	2002		
АНУ	Бүтээлч Манлайллын төв	2005	2005	Манлайллын хөтөлбөр	
АНУ	Харвард Кеннеди Их Сургууль	2010	2010	21-р зууны Дэлхийн Манлайлал ба Олон нийтийн бодлого	

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Огноо	
		Орсон	Гарсан
ХасБанк	Гүйцэтгэх захирал	1998	2009
ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК	Гүйцэтгэх захирал	2009	2010
Сангийн Дэд сайд	Сангийн Дэд сайд	2010	2012
И Ай Ти ХХК	ТУЗ-ийн Дарга	2012	2014
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	Гүйцэтгэх захирал	2014	Одоо

/Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигч/

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр: **Авир**

Өөрийн нэр: **Сүхдорж**

Боловсрол: **Дээд**

Мэргэжил: **Компьютерийн инженер**

Одоо эрхэлж байгаа албан тушаал:

ГрэйпСити ХХК, МОСТ Финтек ХХК-ийн ТУЗ-ийн дарга



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Он		Эзэмшсэн мэргэжил	Зэрэг цол
		Элссэн	Төгссөн		
Монгол	Нийслэлийн 1-р ЕБС	1967	1969	Ерөнхий боловсрол	
Украин	Киев, Политехникийн Дээд Сургууль	1970	1975	Компьютерын инженер	

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Огноо	
		Орсон	Гарсан
Улсын Төлөвлөгөөний Комисс Тооцоолох Төв	Ерөнхий инженер	1975	1988
Улсын Банкны Тооцоолох Төв	Дарга	1988	1991
БСБ Сервис ХХК	Гүйцэтгэх захирал	1991	2007
ГрэйпСити ХХК	Гүйцэтгэх захирал	2000	2008
МОСТ Финтек ХХК	Гүйцэтгэх захирал	2008	2019
ГрэйпСити ба МОСТ Финтек	ТУЗ-ийн Дарга	2019	Одоо

/Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигч/

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр: **Рашле**

Өөрийн нэр: **Бруно**

Боловсрол: **Дээд**

Мэргэжил: **Барилгын инженер, үйлдвэрийн инженер**

Одоо эрхэлж байгаа албан тушаал:

Schroder Adveq - Дэд дарга



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Он		Эзэмшсэн мэргэжил	Зэрэг цол
		Элссэн	Төгссөн		
Швейцар	Швейцар Улсын Технологийн Их Сургууль	1974	1978	Барилгын инженер	Магистр
АНУ	Харвардын Их Сургууль		1990	Ахисан шатны менежментийн программ	
АНУ	Стэнфорд Их Сургууль	1982	1983	Аж үйлдвэрийн инженер	Магистр

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Огноо	
		Орсон	Гарсан
Барилгын төлөвлөлт, Менежментийн дээд сургууль – ETH Zurich	Судалгааны туслах, Туслах багш	1976	1980
Hayek Engineering AG	Инженер	1980	1982
Motor – Columbus AG	Ерөнхийлөгч, Захирал	1983	1993
SFS Stadler Befestigungs – und Umformtechnik AG	Ерөнхий менежер	1993	1996
Schroder Adveq Holding AG	Дэд дарга	1997	Одоо

/Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигч/

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр: **Одончимэд**
 Өөрийн нэр: **Одбаяр**
 Боловсрол: **Дээд**
 Мэргэжил: **Багш, Хуульч**
 Одоо эрхэлж байгаа ажил, албан тушаал:
Ард Даатгал ХК - ТУЗ-ийн гишүүн



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Он		Эзэмшсэн мэргэжил	Зэрэг цол
		Элссэн	Төгссөн		
ЗХУ	Багшийн Их Сургууль	1984	1988	Багш	Бакалавр, Магистр
Монгол	Отгонтэнгэр Их Сургууль	1996	1998	Хуульч, Эрх зүйч	Бакалавр
АНУ	Техникийн их сургууль	1996	1997	Эдийн засагч	Мэргэжил дээшлүүлэх сургалт
АНУ	Харвард Бизнесийн Их Сургууль	2018	2018	Бизнес удирдлага	Мэргэжил дээшлүүлэх сургалт

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Огноо	
		Орсон	Гарсан
УБДС	Багш	1988	1992
МИАТ ХК Бээжин дэх төлөөлөгчийн газар	Менежер	2002	2005
Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ	Атгаше, 3-р нарийн бичгийн дарга, Консул	2005	2010
Засгийн газар	МУ-ын Ерөнхий сайдын зөвлөх	2010	2012
Алтай Холдинг	Дэд ерөнхийлөгч	2012	2016
Гашуун Сухайт ХХК	ТУЗ-ийн гишүүн	2016	2020
Шивээ-Овоо ХК	ТУЗ-ийн дарга	2016	2020
Таван Толгой Түлш ХХК	ТУЗ-ийн гишүүн	2018	2020
Эрдэнэс Монгол	Дэд захирал	2016	2019

/Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигч/

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр: **Пүрэвжаргал**
 Өөрийн нэр: **Батбаяр**
 Боловсрол: **Дээд**
 Мэргэжил: **Эдийн засагч, Санхүүч**
 Одоо эрхэлж байгаа албан тушаал:
Resilience Mining Mongolia Ltd - ТУЗ-ийн гишүүн



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Он		Эзэмшсэн мэргэжил	Зэрэг цол
		Элссэн	Төгссөн		
ИБУИНВУ	Swansea University	1997	2000	Эдийн засагч	Бакалавр
ИБУИНВУ	London Business School	2003	2005	Санхүү	Магистр

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Огноо	
		Орсон	Гарсан
Resilience Mining Mongolia Ltd	ТУЗ-ийн гишүүн	2015	Одоо
Хаан Банк	Байгууллагын Банкны захирал	2014	2015
Интер Групп ХХК	ТУЗ-ийн дарга	2011	2014
Seedrock Mongolia LLC	Гүйцэтгэх захирал	2010	2013
ЕСБХБ, Лондон хот	Natural Resources Banker	2001	2010
Сангийн яам	Эдийн засагч	2000	2001

/Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигч/

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр: **Мөнх-Очир**
 Өөрийн нэр: **Сэргэлэн**
 Боловсрол: **Дээд**
 Мэргэжил: **Нягтлан бодогч**
 Одоо эрхэлж байгаа ажил, албан тушаал:
ТТДС - Гадаад харилцаа эрхэлсэн захирал



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Он		Эзэмшсэн мэргэжил	Зэрэг цол
		Элссэн	Төгссөн		
Монгол	Бизнес Олон Улсын Дээд Сургууль	1998	2000	Эдийн засаг	Бакалавр
Япон	ICT Коллеж	1993	1995	Менежмент	
Япон	BIL	1992	1993	Япон хэл	
Монгол	ТИС	1991	1992	Программ хангамж	
Монгол	Нийслэлийн 23-р Сургууль	1981	1991	Ерөнхий боловсрол	

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Огноо	
		Орсон	Гарсан
Монгол Коосэн Технологийн коллеж	Захирал	2016	Одоо
Техник Технологийн дээд сургууль	Гадаад харилцаа эрхэлсэн захирал	2018	Одоо
Ти Си Ай ХХК	Захирал	1999	Одоо
Монгол Аэропорт Сервис ХХК	Гүйцэтгэх захирал, менежер	1997	2010
Шооэй ХХК (Япон)	Туслах ажилтан	1995	1997

/Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигч/

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр: **Чулуун**

Өөрийн нэр: **Мөнхбат**

Боловсрол: **Дээд**

Мэргэжил: **Эрх зүйч**

Одоо эрхэлж байгаа албан тушаал:

Саусгоби Сэндс ХХК - Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Он		Эзэмшсэн мэргэжил	Зэрэг цол
		Элссэн	Төгссөн		
Монгол	52-р сургууль	1977	1987	Ерөнхий боловсрол	
ЗХУ	ДЯЯ-ны дээд сургууль		1989	Эрх зүйч	Бакалавр
Шинэ Зеланд	Вайкатогийн Их сургууль		1999	Төрийн бодлого, төрийн удирдлага	Магистр

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Огноо	
		Орсон	Гарсан
Саусгоби сэндс ХХК	Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал	2013	Одоо
Азийн хөгжлийн банк	Хөтөлбөрийн захирал	2003	2005
Дэлхийн банк	Төслийн зохицуулагч	2001	2003

/Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигч/

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр: **Зелдович**
Өөрийн нэр: **Михаил**
Боловсрол: **Дээд**
Мэргэжил: **Түүх, улс төр судлал**
Одоо эрхэлж байгаа албан тушаал:
Сосоон Capital - Хяналтын зөвлөлийн дарга



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Он		Эзэмшсэн мэргэжил	Зэрэг цол
		Элссэн	Төгссөн		
Массачусетс, АНУ	Харвардын хуулийн их сургууль	1997	2001	ОУ-ын эдийн засаг, Бизнесийн хууль	Доктор
Массачусетс, АНУ	Fletcher хууль, эрх зүйн их сургууль	1998	2001	ОУ-ын худалдаа	Магистр
Виржини, АНУ	Виллиам, Маригийн коллеж		1997	Түүх, улс төр судлал	Бакалавр

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Огноо	
		Орсон	Гарсан
Green Leafe Capital	Хяналтын зөвлөлийн дарга	2018	Одоо
Сосоон Capital	Хяналтын зөвлөлийн дарга	2017	Одоо
Трафигура Монголиа ХХК	Гүйцэтгэх захирал	2016	Одоо
Капиталын олон улсын хувийн өмчийн сан (CIPEF)	Хөрөнгө оруулалтын ажилтан, ТУЗ-ийн гишүүн	2007	2013

/Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигч/

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр: **Арнауд**
Өөрийн нэр: **Вентура**
Боловсрол: **Дээд**
Одоо эрхэлж байгаа албан тушаал:
Gojo&Company - Удирдах партнер



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Он		Эзэмшсэн мэргэжил	Зэрэг цол
		Элссэн	Төгссөн		
Франц	EFREI		1996	Телеком инженер	
Франц	La Sorbonne		1994	Философи	Магистр

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Огноо	
		Орсон	Гарсан
PlaNNet Finance	Үүсгэн байгуулагч ба гүйцэтгэх захирал	1998	2006
Ваобаб Group	Үүсгэн байгуулагч ба гүйцэтгэх захирал	2007	2019

АРД САХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 30-ны өдөр

№21/01

Улаанбаатар хот

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлан батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 4 сарын 30-ны өдрийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ

/Төсөл №2/

**АРД САХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 4 сарын 30-ны өдөр

№21/02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 4 сарын 30-ны өдрийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр

1. овогтой
2. овогтой
3. овогтой
4. овогтой

2. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр

1. овогтой
2. овогтой
3. овогтой
4. овогтой
5. овогтой нарыг тус тус томилсугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Х.Хулан)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ

Хүчтэй. Хамтдаа.